

УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН АНГИЛЛЫГ  
ӨӨРЧЛӨХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН  
ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦОО

Газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Булган уулын байгалийн дурсгалт газрыг ангилал дээшлүүлэн дархан цаазат газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэрэгжүүлэхэд нийтлэг байдлаараа иргэн, хуулийн этгээд, төрд шинэ чиг үүрэг нэмэх, шинээр үүрэг хүлээлгэх зохицуулалтуудыг тусгаагүй байна.

Харин тогтоолын төсөл батлагдсанаар төрд үүсэх зардлын тооцоог голлон үүрэг гүйцэтгэх байгууллагын хүрээнд буюу Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны хэмжээнд гаргалаа.

Булган уулын дархан цаазат газар болгон Улсын тусгай хамгаалалтад авах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлан хэрэгжүүлснээр төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардлыг дараахь үе шаттайгаар тооцно. Үүнд:

- 1.Тогтоолын төсөл батлагдсанаар төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ нэг бүрийг тодорхойлох;
- 2.Хүний нөөцтэй холбоотой гарах зардлыг урьдчилан тооцох;
- 3.Бусад зардал буюу материаллаг зардлыг нэгтгэн тооцох;
- 4.Хувилбарыг нягтлах.

1.Тогтоолын төсөл батлагдсанаар Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд заасан Дархан цаазат газрыг хамгаалах чиг үүргийн хүрээнд байгаль хамгаалагчийн орон тоог нэмэх асуудлыг шийдвэрлэх үүрэг төрийн байгууллагад үүсч байна.

2.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд зааснаар байгаль хамгаалагч нь байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг таслан зогсоох, гэм буруутай этгээдэд зохих хариуцлага хүлээлгэх нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан байх бөгөөд дархан газрын хэмжээнд 1 байгаль хамгаалагч нэмж ажиллуулах боломжтой.

Засгийн газрын 2006 оны “Дархан цаазат болон байгалийн цогцолборт газарт нэг байгаль хамгаалагчийн хариуцах талбайн хэмжээг тогтоох тухай” 87 дугаар

тогтоолын дагуу тооцоолж үзвэл өргөтгөсөн талбайг хариуцаж ажиллах байгаль хамгаалагчийн орон тоо 1 болгох боломжтой.

Хүснэгт 1

Дэд заалтын дугаар	Нэгж	Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/	Цалингийн зардал /жилээр/	Хүний нөөцийн нийт зардал /төг/
1	Хангайн нурууны БЦГ	1	2,100,000	25,200,000
Нийт		1	25,200,000	

Хүний нөөцийн зардал гэдэгт тухайн үүргийг гүйцэтгэх төрийн албан хаагчийн авч болох нэмэгдэл, тусламж, томилолт, төрөөс даадаг бүх зардлыг нэгтгэн дундажаар гаргасан зардлыг хамрууллаа.

3. Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдснаар байгаль хамгаалагчийн ажлын байр шинээр 1 /нэг/ нэмэгдэхээр байх тул хүний нөөцийн дундаж зардал **25,200,000** төгрөг болж байна.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах нийт зардал **зөвхөн 1 байгаль хамгаалагчийн цалинг** улсын төсвөөс санхүүжүүлэх шаардлагатай байна.

Газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн танилцуулгад энэхүү тайланд тусгасан зардлын тооцоог тусгах нь зүйтэй гэж үзэж байна.